



Уте Кумпф

Германы Бундестагийн гишүүн
“Иргэний идэвх зүтгэл” дэд хорооны орлогч дарга

Германы Бундестаг
11011 Берлин
☎ 030 - 227 – 73 729
📠 030 - 227 – 76 144
✉ ute.kumpf@bundestag.de

Вилхелмсплатц 10
70182 Штуттгарт
☎ 0711 - 23 31 40
📠 0711 - 23 50 99
✉ ute.kumpf@wk.bundestag.de

www.ute-kumpf.de

Уте Кумпф, МдБ (Бундестагийн гишүүн – орч.)

2010.07.30-ны байдлаар

Герман улс дахь ардчилал

Өмнөх үг

Ардчилал гэдэг нь, ард түмэн засгийн эрх мэдлийг барина гэсэн үг. Намууд, нийгэмлэг буюу иргэний хөдөлгөөнүүд, сонгууль ба нийгмийн идэвхт үйл ажиллагаагаар дамжуулан улс төрийн үйл ажиллагаа, шийдвэрт оролцох олон боломж хүн нэг бүрт бий. Улс төрийн мэдээлийг сонсдог, найз нөхдийнхөө хүрээнд маргалддаг хүн ч бас улс төрийн амьдралд оролцож байгаа гэсэн үг.

Ард түмний зөвшөөрлөөр Парламентын ардчилал хүчин төгөлдөр болно. Энэ нь улс төрийн санал бодол бий болох болон шийдвэрлэх үйл явцад оролцох оролцоогоор илэрхийлэгдэнэ. Гэвч оршин суугчдын ихэнх нь шууд улс төрийн идэвхтэй байх ёстой гэсэн үг биш. Жишээлбэл маш бага хэсэг хүн аль нэг намд элсэхэд бэлэн байдаг. 2008 оны сүүлч гэхэд ойлцоогоор 1,42 сая иргэн намын гишүүн байсан нь бүх сонгох эрхтэй хүмүүсийн 2,3 хувь хүрэхгүй тоо юм. Улс төрд оролцох оролцоо олон хэлбэртэй байж болно. Тэрээр улс төрийн шийдэх чадварыг нөхцлөө болгон, нийтийн төлөө хариуцлага хүлээхэд бэлэн байдлыг шаарддаг.

Идэвхтэй оролцоо олон хэлбэртэй байдаг. Гарын үсэг зурах компани ажилд оролцох, эсвэл байгаль орчны, хүний эрхийн талаарх эсвэл өөртөө туслах группийн ажилд оролцоход л оролцож байна гэж үзнэ. Мөн сонинд бичих, парламентын гишүүдэд захиа буюу E-майл бичих эсвэл парламентад буюу Холбооны ерөнхийлөгчид гомдол гаргах зэрэг нь идэвхтэй оролцооны хэлбэрүүд юм. Нам, холбоо, иргэний хөдөлгөөнд гишүүнээр элсэх нь илүү чармайлтыг шаардана. Ард түмнийг төлөөлөх сонгуулиудад оролцох нь онцгой чухал. Харьцангуй цөөхөн хүн тийм сонгуульд нэрээ дэвшүүлэх шийдвэрээ гаргадаг.

Сонгуулиуд

Чөлөөт сонгуульгүйгээр ардчиллыг төсөөлж болохгүй. Ард түмэн сонгуулийн үед засгийн эрхийг тодорхой хугацаагаар төлөөлөгчдөө шилжүүлдгээрээ ардчилсан хяналтын хамгийн чухал хэлбэр нь юм.

Сонгуулиуд улс төрийн оролцооны хамгийн энгийн хэлбэр нь мөн. Иргэдийн ихэнх хэсгийн хувьд сонгуулиуд улс төрийн үйл явцад шууд оролцох ганцхан хэлбэр болдог. Оролцооны бусад бүх хэлбэрүүд илэрхий төвөгтэй.



Сонгуулиуд ардчилал дахь улс төрийн оролцооны хамгийн чухал хэлбэр нь билээ. Сонгуульгүйгээр ардчиллыг төсөөлж болохгүй. Сонгуулиар улс төрийн удирдлагыг сонгож, дараагийн хууль тогтоох байгууллагын хугацааны улс төрийн чиглэлийг тогтоодог.

Сонгуулиуд нь ардчилсан хяналтын хамгийн үр дүнтэй, нөлөөтэй хэрэгсэл: Сонгогчид хэрэв засгийн эрхийг баригчдын бодлогод сэтгэл дундуур байвал, түүнийг халж, засгийг шинээр солих боломжтой.

Германы Бундестаг, Ландтаг (мужийн захиргаа - орч.), орон нутгийн захиргааны сонгуулийн үндсэн зарчмуудыг үндсэн хуулийн 38-р зүйл, Холбооны сонгуулийн хуулийн 28-р зүйлээр зохицуулдаг. Энэ нь германы гишүүдийг Европын парламентад сонгоход ч бас үйлчилнэ.

Үндсэн хуулийн 38-р зүйл

(1) Германы Бундестагийн гишүүдийг ерөнхий, шууд, чөлөөтэй, адил тэгш, нууц сонгуулиар сонгодог. Тэд бүх ард түмний төлөөлөгчид бөгөөд ямар нэг даалгавар, тушаалд захирагдалгүй зөвхөн өөрийн ухамсараар асуудлыг шийднэ.

(2) Арван найман насандаа бүрэн хүрсэн хүн бүр сонгох эрхтэй; нас биед хүрсэн хүн бүр сонгогдож болно.

Сонгуулиуд нь:

- **ерөнхий:** Бүх иргэд тодорхой насанд хүрээд (Германд 18 наснаас) сонгох ба сонгогдох боломжтой болдог;
- **шууд:** Сонгогчид нэг буюу нэг хэсэг гишүүдийг жагсаалтаар шууд сонгоно;
- **чөлөөтэй:** Сонгогчдыг өөрийн саналаа аль нэг гишүүн буюу намд өгөхөд ямар ч тохиолдолд дарамт үзүүлж болохгүй; иргэд сонгох эсэх нь чөлөөтэй, өөрөөр хэлбэл тэдэнд сонгох үүрэг байхгүй;
- **адил тэгш:** Сонгосон санал бүр адил жинтэй тооцогдоно;
- **нууц:** Сонгогч яаж саналаа өгөх нь нууц; сонгох кабин, сонгуулийн хуудас дугтуйн хамт, саналаа хийх хайрцаг буюу бусад хэрэгсэл зэрэг нь нууц байдлын төлөө зүйлс юм.

Германы Бундестаг, Ландтаг-ийн сонгуульд хувь тэнцүүлсэн (пропорциональ – орч.) сонгууль гэж нэрлэгддэг сонгуулийн систем үйлчилдэг. Энэ ихэнхийг сонгох систем нь засгийн эрхийг барих олонхи бүхий хоёр намын системийг бий болгоход тустай. Хувь тэнцүүлсэн сонгууль нь бүх намууд сонгогчдын саналыг авсан хувиараа парламентад суудал эзэлнэ. Таван хувиас доош бол суудал авч чадахгүй.

Бундестагийн сонгууль

Бундестагийг дөрвөн жилийн хугацаатай (хууль тогтоох байгууллагын хугацаа) сонгоно. Бундестагийг сонгоход сонгогч хоёр санал өгдөг. Эхний саналаар тэрээр сонгуулийн тойргийнхоо аль нэг намын нэр дэвшигчийг сонгоод (олонхийн санал сонголт), хоёр дахь саналаараа аль нэг намын жагсаалтыг сонгоно (хувь тэнцүүлсэн сонголт). Жагсаалтад нийт өгсөн саналын дагуу намуудад суудлын тоог хувиарлана. Суудал хувиарлахад хоёр дахь санал гол шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Жагсаалтыг 16 Холбооны улс тус бүрт тусад нь гаргадаг (мужийн жагсаалт).

Германы 2009 оны сонгуулиар сонгож бүрдүүсэн 17 дахь Бундестаг 622 гишүүнтэй. Түүнээс 299 нь сонгуулийн тойргоос шууд, 323 нь мужуудын жагсаалтаас сонгогдсон.

Сонгогч эхний саналаараа өөрийн сонгуулийн тойргийн аль нэг намын нэр дэвшигчийг сонгоод, хоёр дахь саналаараа өөр нэг намын жагсаалтад саналаа өгч болно. Үүгээрээ



сонгогч хэдийгээр аль нэг намд саналаа өгсөн боловч ямар нэг олонд нэртэй нэр дэвшигч Бундестагд ороход дуу хоолойгоо нэмэх боломжтой гэсэн үг.

Ландтагийн сонгууль

Ихэнх Холбооны улсын Ландтагийн сонгуульд ижил сонгуулийн систем, дараах гол шинж чанараараа хүчинтэй: эхний ба хоёр дахь саналаар бий болох хувь тэнцүүлсэн сонголт, таван хувиас доош бол хасагдах эсвэл тоо нь хэт олдсон мандат зэрэг үйлчилнэ. Ихэнх Ландтагийн хууль тогтоох байгууллагын хугацаа голчилж таван жил, харин таван Ландтагийнх дөрвөн жил байдаг.

Орон нутгийн сонгууль

Орон нутгийн төлөөллийн сонгуулиуд Бундестаг болон Ландтагийн сонгуулийн ерөнхий зарчмын үлгэрээр явагдана. Орон нутгийн нэгжүүдийн дарга нарыг сонгох эрэмбэ дараалал одоогийн байдлаар арван хоёр Холбооны улсад өөр өөрийн онцлогтой байна. Сонгогч бүрд тосгоны буюу дүүргийн хурлын гишүүдийг сонгох хэмжээгээр (орон нутгийн нэгжийн хэмжээнээс хамаарч 8-аас 80) санал ноогддог. Сонгогч энэ саналуудыг олон янзын жагсаалтын нэр дэвшигчдэд хуваан тарааж болно. Үүнийг панашийрен (францаар *panacher* = алаглуулах, холих гэсэн утгатай) гэж нэрлэдэг. Тэрээр мөн нэг буюу хэд хэдэн жагсаалтаас өөр өөр нэр дэвшигчдийг сонгон гурав хүртэл санал өгч, нийт сонгогдож буй төлөөлөгчдийн гишүүдийн тоогоор санал өгч болно. Үүнийг кумулийрен (латинаар *cumulus* = овоолох гэсэн утгатай) буюу “Хойфелн” гэж нэрлэдэг.

Намууд

Намууд нь төр ба нийт олныг холбодог холбоос юм. Тэд тодорхой эрх ямбыг эдлэх ба тиймээсээ ч тодорхой шаардлагын хэмжээнд хүрсэн байх ёстой.

Үндсэн хууль бүх намуудад ижил тэгш боломжийг олгодог.

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйл

(1) Намууд ард түмний хүсэл зоригийн үндсэн дээр үйлчилдэг. Тэднийг байгуулах нь чөлөөтэй. Тэдний дотоод зохион байгуулалт ардчилсан үндсэн зарчимтай тохирч байх ёстой. Тэд өөрийн төнгөний гарал үүсэл, хэрэглээ болон эд хөрөнгийнхөө талаар олон нийтэд ил тод тайлагнах ёстой.

Улс төрийн оролцоо нь намуудын үйл ажиллагаагаар дамжиж явагддаг. Тэд хэдийгээр улс төрийн санал сэтгэгдэл, хүсэл зориг бий болоход ганцаар үйлчилдэг биш боловч, улс төрийн амьдралыг нэгтгэж шийвэрлэдэг. Намуудын энэ чухал үүрэг рольд Үндсэн хууль 21 дүгээр зүйлдээ тэдний үүрэг болон хэм хэмжээг зааснаараа хариуцлага хүлээнэ. Үүгээрээ тэд Холбооны үндсэн хуулийн шүүхийн (цэц – орч.) үздэгээр “Үндсэн хуулийн эрх бүхий байгууллагын зиндаанд” хүрдэг.

Намууд улс төрийн хүсэл зориг бүрэлдэн тогтоход доорх байдлаар

- Нийгмийн олон янзын улс төрийн бодол, сонирхлыг илэрхийлэх, түүнийг улс төрийн концепц чиг баримжаа, программуудыг нэгтгэх, улс төрийн асуудлуудын шийдлийг олох,
- Олон нийтэд саналаа танилцуулах, олон түмний санаа бодол, иргэн бүрийн улс төрийн байр суурьт нөлөөлөх,
- Улс төрийн хариуцлага хүлээхийн тулд улс төрд идэвхтэй оролцох, туршлага хуримтлуулах боломжийг иргэдэд олгох,
- Холбоо, муж, тосгодын төлөөлөгчид, улс төрийн байгууллагуудын дарга нарыг томилох,



- Засгийг төлөөлөх нам гэдгээрээ улс төрийн удирдлагыг дэмжих,
- Сөрөг нам гэдгээрээ засгийн газрыг хянах, шүүмжлэх, улс төрийн альтернатив боломжийг олох

зэргээр оролцдог.

Намуудын системийн үндсэн зарчмууд

Үндсэн хууль ба намуудын хууль доорх үндсэн зарчмуудыг намуудын системд тогтоосон:

- Олон намын зарчим: Үндсэн хууль 21-р зүйлээрээ нэг намын системийг хориглодог.
- Намуудын эрх чөлөө: аливаа нэгэн иргэн нам байгуулж болно.
- Боллоцооны эрх тэгш байдал: Аль ч нам сонгуульд оролцож, сонгуулийн компани ажил явуулж болно. Үүний тулд намууд жишээ нь – улс төрийн жин хэмжээнээсээ хамааран урт богино хэмжээний – зурагтын нэвтрүүлэгт цаг авах, харагдахуйц ханан дээр плакатаа наах, олон нийтийн заал, өрөө тасалгааг компани ажилдаа ашиглах зэргийн боломжуудтай.
- Намын доторх ардчилал: Энэ нь намуудад заавал байх зүйл гэж заагдсан байдаг. Бүх төрлийн шийдвэрүүд намын гишүүд буюу намын гишүүдээс сонгосон төлөөлөгчдийн санал хураалтаар шийдэгдэх ёстой. Намын удирдлагын алба нууц сонголтоор хоёр жилийн хугацаатай сонгогдоно. Бүх гишүүд адил тэгш сонгох эрхтэй.
- Санхүүгийн тайлагналт: Намууд өөрийн орлого зарлагыг олон нийтэд тайлагнах ёстой.

Германы социал демократ нам (ГСДН) намын дотоод ардчиллын үндсэн зарчимдаа нэмэлт болгож 1988 онд өөрийн намын дотоод ардчилал дээр хүйсийн эзлэх хувь хэмжээг нэмж оруулсан. Энэ хувь хэмжээний дагуу эр эм аль ч хүйс бүх тэргүүлэгчдийн болон төлөөлөгчдийн дотор дор хаяж 40 хувь нь байх ёстойг заасан. Эрчүүдийн тоо ихэвчилж давамгайлдаг тул, эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээний тухай байнга яригддаг. Бундестагийн болон Европын жагсаалтыг гаргахдаа “цахилгаан товчны зарчим” гэдгийг баримталж, эрэгтэй, эмэгтэйчүүдийг солбиулан нэрлэж жагсаадаг. Мөн Холбоо 90\Ногооны болон Зүүнийхэн намууд бүх албан тушаалд дор хаяж 50 хувь нь эмэгтэйчүүд байхаар заадаг.

Намуудын санхүүжилт

Намуудад өөрийн үүргийг биелүүлэхийн тулд нилээхэн санхүүгийн эх үүсвэр шаардлагатай. Тэд элдэв арга хэмжээнүүд зохион байгуулах, мэдээлийн ба магтан зарлах материал хэвлүүлэх, тараах болон сонгуулийн компани ажил явуулах зэрэгт зориулж орон нутгийн нэгжээс Холбоо хүртэл өргөнөөр тархан салбарласан байгуулагадаа олон арван орон тооны ажилтнуудтай. Намуудын орлого голчилж гишүүдийн татвар, хандив болон татварын мөнгөнөөс бүтдэг. Аливаа ашиг сонирхол хөөсөн бүлгүүд намд нөлөөлөх нөлөөллөөс хамгаалахын тулд хандивыг хязгаартай байлгах хэрэгтэй.

Нам тус бүр жилдээ дөрвөн сая хүртэл сонгогчийн санал авч, санал тус бүр 0,85 евро, цааших санал тус бүр 0,70 евро гэж тооцон авдаг. Хандивын татвараас чөлөөлөгдөх хэмжээ жилдээ хүн тус бүрт дээд тал нь 3300 еврогоор тогтоогдсон. Пүүс фирмүүдийн хандивыг татвараас чөлөөлөхгүй. Гишүүдийн татвар ба хандиваар орсон орлогын евро тус бүрт 0,38 еврог намуудад татварын мөнгөнөөс нэмж олгодог. Намуудад улсаас олгох нийт мөнгө 2002 оноос хойш жилд 133 сая еврогоос дээшгүй байхаар хязгаарласан. Хандивыг Бундестагийн ерөнхийлөгчид ил тод тайлагнах үүрэгтэй. Бундестагийн ерөнхийлөгч жил бүр Бундестагд намуудын хандивын тухай илтгэдэг.



Намууд санаа бодлын зөрөлдөөний үед

Германд, зөвхөн тэнд ч биш, намууд болон улс төрчид маш хүчтэй, заримдаа эх захгүй шүүмжлэлд өртдөг. Шүүмжлэл олон талаар иш үндэстэй байдаг. Сүүлийн жилүүдэд улс улс төрчдийн буруугаас болж зарим нэгэн шившигтэй алдаат явдлууд гарсан жишээ бий. Холбооны үндсэн хуулийн шүүх залруулсан намуудын санхүүжилт ба намуудад олонтаа байдаг албан тушаалаа намын эрх ашгийн төлөө ашиглах явдал нь шүүмжлэх ёстой зүйлийн нэг мөн. Түүнчлэн олонхи сонгуулийн компанит ажил, сонгуулийн сурталчиггаа зэргийн эсрэг үндэслэлтэй эсэргүүцэл үзүүлэх шаардлага хааяа гардаг.

Хэрэв шүүмжлэл ерөнхийлсөн, намууд болон улс төрчдийг хардаж сэрдсэн байдалтай бол уг шүүмжлэл хэтрүүлсэн эсвэл зүй бус. Тийм шүүмжлэлүүд ихэвчлэн улс төрчдийн ажлын ачааллыг бага гэж ойлгох, тэдний авдаг цалинг хэт өсгөж бодох зэрэг атгаг санаа буюу ойлголт муутай байдлууд дээр тулгуурласан байдаг.

Ардчилал дахь иргэний нийгэм

Үндсэн хууль нь иргэдийн сайн дураараа нийгэмлэгт нэгдэж, зохион байгуулагдан, хамтын ашиг сонирхлоо хамгаалах явдлыг баталгаажуулдаг.

9 дүгээр зүйл

(1) Бүх германчууд нийгэмлэг, холбоо байгуулах эрхтэй

(2) Зорилго, үйл ажиллагаа нь эрүүгийн хуулийг зөрчсөн, эсвэл үндсэн хуулийн дагуух ёс журам буюу ард түмнүүдийн ойлголцлын эсрэг байдлаар нэгдэхийг хориглоно.

Иргэд намд харьцангуй бага элссэн байхад, маш олон иргэд ямар нэг нийгэмлэг буюу холбооны гишүүн байдаг. Германы Холбооны нийгэмлэгийн холбооны тоо баримтаар 2008 онд Герман улсад 554 мянган бүртгэгдсэн нийгэмлэг, холбоонууд байлаа.

Улс төрийн сонирхол бүхий 5 мянга гаруй холбоо байдаг нь нийлээд ижил сонирхолтой холбооны нэгдэл болж байгаа юм. Холбооны бодлогын сонирхол бүхий тэргүүлэгч нийгэмлэгүүд (2009: 2.139) Германы Бундестагийн ерөнхийлөгчийн хөтлөдөг жагсаалтад ("Лоббилите") орсон.

Холбоо нийгэмлэгүүд нийгмийн аль ч салбарт оршдог. Тэднийг үйл ажиллагааны байдлаас нь болж таван хэсэгт хуваана:

- Эдийн засгийн амьдрал болон хөдөлмөрийн хүрээний холбоо нийгэмлэгүүд
- Нийгмийн зорилготой холбоо нийгэмлэгүүд
- Чөлөөт цаг, амралтын хүрээний холбоо нийгэмлэгүүд
- Соёл, шинжлэх ухааны хүрээний холбоо нийгэмлэгүүд
- Оюуны болон нийгмийн бодлогын зорилготой холбоо нийгэмлэгүүд

Бундестаг болон Холбооны засгийн газрын ажиллагааны журамд сонирхол нэгт холбоодын оролцоог тусгагасан. Тэдний төлөөлөгчдийг Бундестагийн хороодоос санал асуух, нийтээр хэлэлцэх асуудалд (хеарингс) хариу өгөх болон энкүетт комисст оролцуулдаг. Яамдуудыг ч хуулийн төсөл хийх үедээ уг тэргүүлдэг нийгэмлэгүүдийн төлөөлөгчдийг татаж оролцуулж байхыг шаарддаг.

Ер нь холбоонуудын мэдлэг, магадлал туслалцаа хэрэгтэй болдог. Үүгээр хуулиуд дутмаг, алдаатай болох явдлыг багасгадаг.



Эвслийн эрх чөлөө ба тарифын автономии

Үйлдвэрчний эвлэл болон ажил олгогчдын холбоод бусдынхаа дунд онцгой байр эзэлдэг. ҮХ-ийн (Үндсэн хуулийн – орч.) 9 дүгээр зүйл, 3 дугаар хэсэгт эвслийн эрх чөлөө, “ажлын болон эдийн засгийн нөхцлийг хамгаалах, дэмжих нэгдэл холбоодыг байгуулах” эрхийг баталгажуулдаг. Төр ажиллагсад ба ажил олгогчдын холбоонд ажлын харьцааны асуудлын зохицуулалтыг шилжүүлсэн.

Тэд тарифын түнш гэдэг утгаараа биеэ дааж (автономи) цалин, ажиллах нөхцлийг зохицуулах ба тарифын талаар биеэ даасан байдалтай. Тэдний хэлэлцээ тохиролцоо нь тарифын түнш байгууллагуудын гишүүдийн хувьд хүчин төгөлдөр ба асуудал гарвал ажлын шүүхээр заргалдах боломжтой. Тарифт цалингийн гэрээнүүдийг (*Lohntarifverträge*) ихэвчилж богино хугацаатай (нэгээс хоёр жил) байгуулдаг ба түүгээр голчилж цалингийн төлбөр, цалин хөлс, сургалтын үед олгодог тусламж зэргийг зохицуулдаг. Урт хугацааны буюу ерөнхий гэрээнүүдт; (*Mantel- oder Rahmentarifverträge*) хэд хэдэн жилийн хугацаатай байгуулагдах бөгөөд ерөнхийдөө ажлын цаг, амралт, илүү цаг төлөлт, шөнө болон баярын өдрүүдийн ажил, цалингийн групп зэрэг асуудлуудыг тусгадаг.

Тарифын хэлэлцээ амжилтгүй болвол хөдөлмөрийн тэмцэл явуулж болно. Үйлдвэрчний эвлэл ажил хаялт зарлах, ажил өгөгчид хүмүүсийг ажлаас халж болно. Бусад үйлдвэржсэн орныг бодвол Герман улсад ажил хаялт харьцангуй бага гардаг. Үүнд үйлдвэрчний эвлэлүүд пүүс фирмүүдийн эсрэг тарифын автономын систем хүчтэй сөрөг хүч болдог нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Германы үйлдвэрчний эвлэлийн эдийн засгийн нэг салбарт ажиллагсад бүгд нэг тарифын гэрээний дотор багтдаг зохион байгуулалтын зарчимтай тул тарифын гэрээний хугацаанд ажил хаялт хийх нь хориотой.

Сүм хийдүүд

Төр ба сүмийн харьцааг үндсэн хуулиар зохицуулдаг. Үндсэн хуулинд шүтлэгийн хамт олон нийлэн нэгдэх эрх чөлөөг олгож, шүтлэгийн хамт олон дотоод асуудлаа өөрөө зохицуулж байх тухай заасан.

Төр ба сүмүүд нягт холбоотой бөгөөд сүмүүд нилээд их эрх мэдэлтэй. Сүмүүд жишээлбэл сүмийн татвар авах эрхтэй. Сүмийн татварыг улсын санхүүгийн байгууллагаас татаж авдаг нь төрөөс сүмд үзүүлж буй үйлчилгээ бөгөөд сүм түүнд гарсан зардлыг төлдөг юм.

Түүнчлэн тэд улсын сургуулиудад шашны хичээл заахыг (ҮХ-ийн 7-р зүйл, 3-р хэсэг) зохицуулах, их сургуулиудад шашны тэнхим зохион байгуулах, Бундесвеерт (Холбооны арми – орч.) болон бусад улсын албан байгууллагад шүтлэгийн тусламж өгч байх боломжийг (Ваймарын Эзэнт улсын Үндсэн хуулийн 141-р зүйл) бий болгох эрхтэй.

Сүмүүд төрийн нийгмийн үүргүүдийн нилээдийг өөртөө авдаг: Тэд эмнэлгүүд, хүүхдийн цэцэрлэгүүд, өндөр настны асрамжийн газрууд, нийгмийн болон асран тэтгэх байгууламжууд зэргийг ажиллуулдаг. Тэдний зардлын зарим хэсгийг сүмийн татвараас гаргаж, дараа нь улсын хөрөнгөөр нөхдөг.

Ромын католик сүм 2009 оны сүүл үед ойр. 25,2 сая, Германы евангелийн сүм (ГЕС) ойр. 24,8 сая гишүүдтэй байлаа. Энэ нь бүх хүн амын тус бүр 31 хувь шахам нь юм. Дээр нь 2 сая гаруй Евангелийн чөлөөт сүм болон ортодокс (туушт үзэлтний – орч.) сүмийн гишүүд нэмэгдэнэ. Үүнээс гадна Герман улсад 2009 оны сүүлчээр 3,5 сая лалын шашинтангууд амьдарч байлаа.

Иргэний хөдөлгөөнүүд

1960-аад оны сүүл хавиар “суурь ардчилсан” улс төрийн оролцооны шинэ хэлбэр буй болсон. Ихэвчилж орон нутгийн хэмжээнд харш байдлуудыг (ж: байгал орчны аюул занал, хуучны дурсгалт барилгыг нураах, хүүхдийн цэцэрлэг, тоглоомын талбай, жижиг хэмжээний сургуулиудын орчинд зам байгуулах төлөвлөгөө зэргийн эсрэг) арилгахын тулд хүмүүс



аяндаа нэгдэж “иргэний хөдөлгөөнүүд” бий болдог. Иргэний хөдөлгөөний онцлог шинжүүд нь

- хязгаарлагдмал зорилготой бөөгнөрөл (one-purpose organizations),
- богино хугацаанд маш их талархагчдыг татан дайчлах чадвартай,
- орлого сайтай, боловсрол өндөртэй дунд давхаргаас эгнээндээ элсүүлдэг.

Ийм хөдөлгөөнүүд сүүлдээ нутаг орноосо хальж, холбоо хэлбэртэй байгууллага болсон. Жишээлбэл байгал орчныг хамгаалах ихэнх хөдөлгөөнүүд 1972 онд нэгдэж “Байгал хамгаалах хөдөлгөөнүүдийн холбоо” болсон. (2008 онд уг Холбоонд ойр. 150 мянган идэвхтэй гишүүдтэй 120 иргэний хөдөлгөөнүүд багтаж байлаа.) Том проектуудын эсрэг зохион байгуулалттай өргөн олны арга хэмжээнүүд зохиогдож байдгаараа онцлог шинжтэй (ж: Вийл, Калькар, Брокдорфын атмын цахилгаан станц, Фракфуртын онгоцны буудлын баруун талын хөөрөх зам). Үүнд тэд гудамжийг хааж бөглөх, сит-инс (суулт – орч.), гоу-инс (явалт – орч.) ба харуул гаргах зэрэг арга хэмжээний шинэ хэлбэрүүдийг хэрэглэв.

Байгал орчныг хамгаалах, эмэгтэйчүүдийн, энх тайвны хөдөлгөөнүүд жишээлбэл нийгмийн болон эрүүл мэндийн сектороос хүмүүсээ элсүүлдэг гэх мэтээр хоорондоо хэдийгээр зорилго, зохион байгуулалтын хэлбэрийн ялгаа ихтэй боловч сүүлд гарсан бүх хөдөлгөөнүүдийг “нийгмийн шинэ хөдөлгөөнүүд” гэж нэрлэдэг.

Тэдний эхлэл болох 1970-аад оны эхэн үе нь альтернатив улс төрийн хэв маягуудын дараах улс төрийн соёлын ба хэрэгцээ шаардлагын өөрчлөлтийн илрэл байлаа. Вилли Брандт энэ сонирхлыг өөрөө засгийн эрхэнд байх үедээ „Бид өшөө илүү ардчилалд зориглоно“ гэсэн уриатайгаар хүлээн авсан. Иргэний хөдөлгөөнүүд болон Нийгмийн шинэ хөдөлгөөнүүдийн хүрээнээс ногооны ба альтернатив намууд бий болж, 1980 онд “Ногоонтны” нам болон нэгдсэн.

1970-аад оны эцсээр БНАГУ-д үүссэн иргэний хөдөлгөөнүүдийг өөр улс төр, нийгмийн ерөнхий нөхцлөөс нь болж Нийгмийн шинэ хөдөлгөөнүүдтэй харьцуулах аргагүй юм. Сөрөг хүчнийхэн төрийн зүгээс үзүүлдэг хүчтэй дарамтыг давж, ардчилсан үндсэн эрхээ хамгаалахын тулд голчлон жижиг, албан бус дугуйлангуудыг байгуулдаг байв. “Эргэлтийн” үед тэд ГСНН-ыг (Германы социалист нэгдсэн нам – орч.) эсэргүүцэгчдийн цугларах төв болж; “дугуй ширээ” гэгчийг байгуулан, ардчисан өөрчлөлтийг удирдан явуулсан. Баруун Германых байсан намуудын нөлөө өссөний улмаас энэ хөдөлгөөнүүдийн үйлчлэх хүч 1990 он гэхэд ихэд суларсан байлаа.

Шууд ардчилал

Шууд ардчилал нь Герман улсад өөр өөр илрэлтэй гурван түвшинтэй бөгөөд дороосоо дээшээ багасч үйлчилдэг:

- **Коммунууд** (ж. Барилгын төлөвлөлт, төсвийн төлөвлөгөө, иргэдийн хүсэлт, шаардлага, иргэдийн шийдвэр)
- **Мужууд** (муж тус бүрийн дүрмээр ж: ард түмний шийдвэр; үндсэн хуулийн өөрчлөлт; Ландтагийг тараах)
- **Холбоо** (ҮХ-ийн 17-р зүйлийн дагуу хамт олон гомдол гаргах эрх, ҮХ-ийн 29-р зүйлийн дагуу Холбооны газар нутгийг шинээр хувиарлах, ҮХ-ийн 146-р зүйлийн дагуу шинэ үндсэн хууль)

Үндсэн хуулинд Холбооны хэмжээгээр одоог хүртэл шууд ардчилсан эрхүүдийг заагаагүй байгаа. Зөвхөн шинэ үндсэн хууль хүчин төгөлдөр (ҮХ-ийн 146-р зүйлийн дагуу) болох тохиолдолд ард түмэн шууд оролцох болно. ГСДН 90-ээд оны дунд үеэс хойш Холбооны түвшин дэх ард түмний шийдвэрийн төлөө саналаа өгч байгаа. Бундестагд өнөөг хүртэл 2/3-ын харьцаатай дийлэнхийн ялалт гараагүй л байна.

Коммунуудын түвшинд улс төрд шууд нөлөөлөх олон боломжууд бий. Сонсох үүрэг гэж байдаг нь, жишээлбэл барилга барих төлөвлөгөөний өөрчлөлт, эсвэл гудамж байгуулах шийдвэр гаргах зэрэгт иргэдийн саналыг сонсох, тэдний хүсэлт гомдлыг тусгах ёстой. Мөн төсвийн төлөвлөгөөг бүх ард түмэн уншиж үзэх боломжтой байх ёстой бөгөөд ямар нэг эсэргүүцэл гарвал, түүнийг шүүн хэлэлцэх ёстой. Германы зарим нутагт коммунуудын



түвшин дэх иргэдийн хүсэлт, шаардлага гэж байдаг. Иргэд чухал асуудлуудын талаар коммуны нутаг дэвсгэрийн байгууллагад (ж. тосгоны, мужийн, дүүргийн захиргаа г.м.) иргэдийн шийдвэр гаргах өргөдөл өгч болно. Уг өргөдөлд сонгох эрхтэй иргэдийн тодорхой хэсэг нь гарын үсэг зурсан байх ёстой. Мужийн буюу холбооны түвшинд үүнийг ард түмний хүсэлт шаардлага гэж нэрлэдэг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн санаа бодолд маш их нөлөөтэй, тэд мэдээлэл хийснээрээ улс төрийн оролцоог боломжтой болгодог. Германд хувийн ба олон нийтийн байгууллагууд хоорондоо өрсөлддөг.

Үндсэн хууль нь санаа бодлын, мэдээллийн, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалдаг. Үүгээрээ төрийн халдлагаас хамгаалах хамгаалалтыг баталгаажуулдаг. Үүнд бас: санаа бодлоо хэлэхэд шийтгэлгүй; хэвлэх мэдээлэхийг төрөөс хянах, дарамтлахыг хориглоно; албан байгууллагууд хэвлэл мэдээллийн байгууллагад хариулах, мэдээлэх ёстой; сэтгүүлчид мэдээлэл өгөгчөө нэрлэх шаардлагагүй зэрэг орно. Цаашилбал үндсэн хууль хэн нэгнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээс хамгаална. Доромжлол, гүтгэлэг нь шийтгэлтэй. Болсон явдлыг хэвлэл мэдээлэлд худлаар тайлбарласан бол – гэхдээ дүгнэлт буюу саналаа илэрхийлэх энд орохгүй – түүний эсрэг тайлбараа өгөх эрх бий.

Үндсэн хуулийн 5-р зүйл

(1) Хүн бүр өөрийн санаа бодлоо үгээр, бичгээр, зургаар чөлөөтэй илэрхийлэх, тараах болон нийтэд хүртээлтэй газруудад элдэв саадгүйгээр мэдэгдэх эрхтэй. Хэвлэх ба радио, киногоор мэдээлэх эрх чөлөөг олгоно. Хяналт байх ёсгүй.

(2) Эдгээр эрхүүд нь ерөнхий хуулиудын зааврууд, залуучуудыг хамгаалах хуулийн заалтууд болон хувийн нэр төрөө хамгаалах эрхээр хязгаарлагдана.

Нийт олны ардчилал дахь улс төрийн оролцоо нь хэвлэл, радио, зурагт болон интернетээр дамжиж явагдах боломжтой. Тухайн хүн мэдээлэл авсан, ялгаатай санаа бодлуудтай танилцаж, хооронд нь харьцуулсан байж л улс төрийн шийдвэрээ гаргах боломжтой болох нь ойлгомжтой. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийг бий болгож, нийгмийн хэсгүүд болон байгууллагууд, нам, намын байгууллагуудын олон янзын улс төрийн үзэл санаагаа солилцдог. Үүнээс үүдэж хэвлэл мэдээллийн хэрэгслийн онцгой хариуцлага үүсдэг юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл доорх үүрэгтэй

- Мэдээлэл тараах,
- Иргэдийн санаа бодол бүрэлдэн бий болоход хувь нэмрээ оруулах,
- Улс төрийн байгууллагуудын шийдвэр түүнчлэн албан хаагчдын биеэ авч яваа байдлыг хянах, муу муухай байдлыг шүүмжлэнэ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг шүүмжлэх шүүмжлэл

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх мэдэл болон түүнийгээ хэрхэн ашиглаж байгаа хэлбэр, арга замаас болж шүүмжлэл гардаг. Тэрээр “дөрөв дэх захиргаа” гэж нэлэгддэг боловч түүнд ардчилсан хуулийн эрхчлэл дутдаг гэгцгээдэг юм. Олон сэтгүүлчид өөрийн мэдээлэлдээ хувийн, аль нэг талыг дэмжсэн бодол санаагаа тусгадаг. Улс төрийн бодлогыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаад бас шүүмжлэл гардаг:

Юуны урьд зурагт болон шар сонингоор

- хэцүү төвөгтэй зүйлсийг хялбаршуулж,
- ялимгүй явдлыг хэт өсгөн төвийлгөж,
- ажил хэргийн асуудлыг хувийн болгон тавьж,



- ямар нэг сэдвийг дараа нь гэнэт огт хэрэггүй болгохын тулд богино хугацаанд хүчтэй шуугиулан,
- зай завсаргүй шахам муу мэдээнүүд мэдээлж, хорвоогийн итгэл мөхөс дүр зургийг бий болгодог.

Ийм шүүмжлэлийн хажуугаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл ардчилсан нийгмийн зайлшгүй нэг хэсэг нь гэдгийг анхаарахгүй байж болохгүй. Тэд улс төрийн шийдвэрүүдийг ил тод болгож, эрх мэдлээ буруугаар ашиглах, дур зоргоороо аашлах, авилгах зэргийг хянах чухал үүргийг гүйцэтгэдэг.

Хэрэглэсэн материал:

Хорст Пееч, *Германы ардчилал*, Бонн, Холбооны улс төрийн боловсролыг төв, 2009 он